

100 төгрөгтэй явснаас

100 найзтай явсан нь дээр хэмээх эртний Монгол ардын зүйр цэцэг үгийн утга XXI зууны босгон дээр түүнийг ойлгож хүлээн авах ойлголт даяаршсан урсгалд урсан алга болж буй мэт. Учир нь хүнд 100 найз байтугай гарын арван хуруунд хүрэх сайн хүнийг олж нөхөрлөнө гэдэг эргэлзээтэй болсон үе. Миний хувьд найзаас илүү өөрийн ажил үйлс, хүч хөдөлмөрөөрөө бий болгосон 100 төгрөг үнэ цэнтэй мэт санагдана.

Энэ жил Монгол улс мөнгөн дэвсгэрттэй болсон онцгой үйл явдлын 100 жилийн ой тохиож байгаа нь өөрийн эрхгүй мөнгийг сонирхон судлах хүсэл төрлөө. Төгрөгийн загвар, дүрслэлд түүх, соёл, үндэсний онцлогийг шингээхээс гадна аюулгүй байдлын баталгаанд шинэ шинэ дэвшлүүд гарчээ. Мөнгө бол хүмүүсийн амьдралын чухал хэрэгсэл төдийгүй хүн төрөлхтөн, улс орны хөгжлийн түүхийг илэрхийлэх цаг хугацааны бэлгэ тэмдэг юм. Мөнгөнд хүний хүсэл амьдралын үнэ цэн, мөрөөдөл эрмэлзэл бүр цаашлаад эх орны хөгжил дэвшил бүгд хүний бүтээсэн хөдөлмөрийн үр шимээр бий болж түүнийг үнэлж хэмжих хэмжүүр нь цалин буюу төгрөг “та” билээ. Цаг хугацааны эрхээр мөнгөнд өөрчлөлт гарсан ч түүнд хандах хүмүүсийн хандлага улам нэмэгдэнэ үү гэхээс буурч байсан удаагүй ээ. Өнө мөнхөд үнэ цэнээ алдахгүй хамгийн сайн сайхан зүйл гэвэл хүн бүхэн таныг л нэрлэнэ байх даа. Олон зууны туршид нийгмийн өөрчлөлтийг дагаад, ирээдүйд үүсэх эдийн засгийн уналт ба өсөлтийг тооцоолох, хүний амьдралд тохиолдох жаргал ба зовлонгийн заагт үйлчлэх чухал хэрэгслийн нэг нь мөнгө.

Түүхийн хуудсыг сөхөж үзвэл эрт дээр үеэс л хүмүүс өөрт нь хэрэгтэй зүйлийг хувьдаа байгаа зүйлээр солилцон худалдан авалт хийдэг байсныг бид мэднэ. Тухайн үед мөнгө эртний үнэт чулуулаг алт мөнгөөр орлуулагддаг байсан бол цаг хугацаа урсан өнгөрч бартерлахад өөрчлөлт орж НТӨVII зуунд зоосон мөнгийг Лидийн хаант улсад анх үүсэж, олон улсын худалдаа арилжааг амар хялбар болгосон нь одоо ч зарим улсад хэрэглэгддэг. 1925 онд Монгол улс анх удаа өөрийн мөнгөн дэвсгэрт буюу “төгрөг”-ыг гаргаснаар эх орон минь санхүүгийн хөгжилтэй эдийн засгийн хувьд бие даасан байдлыг олж авч чадсан. Мөнгөн тэмдэгттэй байна гэдэг нь тусгаар тогтносон Монгол улсын эдийн

Амьдрал орчин түүхийн шинэ зүйлсийг туулж явсаар цаасан мөнгө гэдэг зүйл дэлхий дахиныг гайхшируулж олон улсын хэрэглээ бараа бүтээгдэхүүнийг худалдан авдаг тоон дэвсгэрт - үнэт цаас болжээ. Үүнээс хойш хэдэн зуун жил дамжин явсаар ХХI зуунд банкны систем, валютын орчин хүчээ авч цахим мөнгө, виза карт гэх зэрэг хорвоо дэлхийд шинэчлэгдсэн сонин содон зүйл гарч ирлээ. Хүмүүс бүх төлбөр тооцоо, худалдан авалтаа цахимаар түргэн шуурхай хийж хэвшсэнээр цаасан мөнгийг заавал биедээ авч явах шаардлагагүй болж төгрөгийн эргэн тойронд гайхмаар өөрчлөлтүүд орж ирснийг бид биеэрээ хүртэж байна.

Хүн мөнгийг олоход маш их баярладаг хэр нь алдахдаа гуниглаж сэтгэл санаагаар унаж зовдог нь мөнгөний утга учир түүнд л орших мэт. Мөн ажил хөдөлмөрийн хөлс болох цалингийн өсөлт бууралт, тэгш бус хуваарилалт нь хэн бүхний сэтгэл зүйд шууд нөлөөлдөг жамтай. Мөнгө нь хүний хүсэл мөрөөдөл зорьсон эрх мэдэл амжилтыг илэрхийлж чаддаг зүйл бөгөөд өнөөдөр хүний амьдралд мөнгө ямар байр суурь эзэлж байгаа нь хүнд зайлшгүй хэрэгтэй зүйл гэдгийг нотолно.

Мөнгөний ач холбогдол хүн төрөлхтөнд үргэлж байсаар ирсэн ч түүнийгээ өсгөхөд хувьцаа болон бонд зэрэг олон төрлийн зүйлд хөрөнгө оруулалт хийж болдог болсон эрин үе. Олон улсын банк нь санхүүгийн шинэчлэлүүд цаг хугацааны урсгалд өөдөө тэмүүлж буй жигүүртэн мэт улам өндөр лүү дэвшин явж байна. Улс орныг тухайн орных нь валютын ханшаар дүгнэж бас болох юм. Мөнгөний ихэнх урсгал нь дундаж болон түүнээс дээш (элит) хэсэгт хуваагддаг нь нууц биш. Тэгвэл баялгийн хуваарилалт ямар хэлбэртэй байгаагаар нийгэм амжилттай хөгжин дэвшиж буйг мэдэж болох болов уу?

Үүний илэрхийлэл нь цахим мөнгөний өргөжилт юм. Илүү хурдан шуурхай хялбар аюулгүй байдлаар эдийн засгийн үйл ажиллагааг дэмжиж шинэ хөгжлийн чиглэлд шилжиж байна. 2009 онд монголын томоохон банк болох “Хадгаламж банк” санхүүгийн хяналтгүй удирдлагаас болж том уналтад орж байсныг одоо судалъя. Энэ зүйлээс үүдэн олон мянган хүний хадгаламж эрсдэлд орж улсын төсвөөс асар их мөнгөөр нөхөн төлж ганц хадгаламж биш банктai нийлүүлэх бодлого явуулсан. Мөнгө нь зөвхөн хувь хүний бус улс орны дэвшил амар тайван Тогтвортой байдлыг илтгэдэг өөрийгөө тольдох усны тусгал юм.

2020 оны 10 сард “E-Mongolia” нь төрийн 1200 гаруй үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдийн хүртээлд нийцэж 2024 оны байдлаар 1.8 сая хэрэглэгчтэй болон дэвшиж байна. Мөн “E-Business” платформоор дамжуулан 6000 гаруй шинэ бизнес манай улсад бүртгэгдсэн нь эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлжээ. Орчин үед цахим ертөнц үүсэн хөгжиж байгаатай холбоотойгоор олон нийтийн сүлжээгээр мөнгөний үнэ цэнийг хүүхэд багачуудад таниулах санхүүгийн боловсролтой хүмүүсийн туршлага, түүхийг бусдад дэлгэрүүлэх зорилгоор улсын болон хувийн хэвшил цаашилбал төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Энэ нь хүнд багаас нь мөнгөний үнэ цэнийг ойлгуулснаар том болоод өөрт хүндрэлтэй үед өөрийгөө хамгаалах мэдлэгтэй болгох нь эрсдэл давах гол тулгуур хүчин зүйл юм. Зөв мэдлэгтэйгээр бага дүнгээр хөрөнгө оруулалт хийж сурах нь ирээдүйд тогтвортой байдлыг хангана.

2025 оны хоёрдугаар сарын 26 өдөр Монголбанк боловсролын ерөнхий газартай хамтран ахлах ангийн сурагчдын дунд “Level-UP” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ шинэ санаачилга хот, орон нутагт хэрэгжиж эхэлсэн нь бидэнд үр дүнгээ өгч эхэлсэн. Бага ч болов хугацаанд мөнгө гэдэг зүйл бидэнд ямар их хэрэгтэй гэдгийг ухааруулж насанд хүрсэн хойно оо ямар ч мэдлэггүй ямар ч төлөвлөлтгүй байх байсан мэдлэгт энэхүү хөтөлбөрөөр дамжуулж санхүүгийн боловсролд суралцаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг таниулж өгсөнд баярлалаа.

Монгол төгрөгийн үнэ цэнэ зөвхөн манай улсаас хамаарахгүй гадаадын орнуудын долларын ханш түүхий эдийн үнээс хамаардаг. Манай орны төсөв нь уул уурхайгаас хэт хамааралтай болохоор байгалийн хатуу эдийн үнэ буурахад төгрөгийн ханш буурдаг. Урт хугацаанд эдийн засгийн бүтэц хөрөнгө оруулалтыг сайжруулж хойч үедээ өвлүүлэн мөнгөний үнэ цэнийг таниулах нь төгрөгийн бүтээмжийг хамгаалах үндэс болно. Миний бодлоор монголчууд зуун зуун дамжин өнгөрч он цаг ус шиг урсаж хүн төрөлхтний амьдрал оюун ухаан улам дээшилж хот суурин нэмж баригдан хүмүүс утасгүй картгүй бараа бүтээгдэхүүн худалдан авдаг болсон ч эх орныхоо үнэт цаас төгрөгийг хэн хэндээ сэтгэлийг бэлэг болгон өгч амьдрал ахуйдаа ашиглаж үеэс үед дамжин нэвтрүүлэх нь зөв.

Манай аав ээжийн арван төгрөгөөр талх авч тавин төгрөгөөр гутал авдаг байсан бол одоо хүүхэд багачууд бага мөнгөн дэвсгэртийг тоохоо больж хэний ч хүрэхгүй тоостой газар бидэнд гомдон уйлж байна уу гэлтэй хэвтэх нь олонтоо. Төгрөгийн ханшийг тогтоон барихад Монголбанкны үйл ажиллагаа их байдаг. Монгол хүн бүр өөрийн улсын мөнгөн дэвсгэртийг хайрлан хамгаалж түүнийгээ хуримтлуулан арвижуулбаас эх орон эдийн засаг дагаад хөгжих нь дамжиггүй.

Мөнгө бол хэрэглээ биш харин миний ирээдүйн зорилго мөрөөдлөө биелүүлэх түлхүүр гэж би үздэг. Хайртай хүнтэйгээ гэрлэж гэр бүлээ тэжээхэд, тогтвортой мэргэжил эзэмших зэрэг олон зорилго минь мөнгөнөөс хамааралтай. Хүний амьдрал тогтвортой эдийн засгийн баталгаатай байх нь гэр бүл амар амгалан юугаар ч дутахгүй амьдрахад нөлөөлөх нь ойлгомжтой. Мөнгө хүнийг мөнх настай болгохгүй ч өвчтэй хүнийг эрүүл болгоход хэрэг болно гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ.

Мөнгө бол зүгээр нэг цаас биш. Цаг хугацаа нисэн одох үед тухай орныг илтгэдэг хүний амьдралын үнэт зүйлсийн илэрхийлэл юм. Хүн бүтээлч ажилсаг байхын хирээр бид нар мөн адил үргэлж дээшээ тэмүүлнэ. Эд бараанаас авхуулаад, мөнгө бий болсоор цахим хэлбэрт шилжтэлээ их замыг туулахдаа өөрийн үнэт чанараа алдахгүй дэлхийн 7 тэрбум хүний хүсэл мөрөөдөл үүнд л зөвхөн шингэсэн байдаг, байсаар ч байгаа. Цаашид ч байсаар байх болно.

**Орхон аймгийн Баян-Өндөр сумын
Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль,
10а ангийн сурагч Д. Доржий-Нямбуу**